

МЭДЭЭЛЛИЙН НИЙГЭМ БОЛОН
ТҮҮНИЙ ШАЛГУУРЫН ТУХАЙД

З.Серик*

* Японы Кобегийн их сургуулийн докторант, социологич

Түлхүүр үг: мэдээллийн нийгэм, цахим эдийн засаг, рефлексив шинэчлэл, тэмдэгтийн тэсрэлт, постмодернизацийн эрин, виртуаль эдийн засаг, даяар тосгон, нөлөөллийн онол

Орчин үеийн нийгмийн шижлэх ухааны судлаачдын анхаарлын төвд байгаа нэг чухал сэдэв бол мэдээллийн нийгэм, түүний онцлог шинж, шалгуурын тухай асуудал юм. Энэ асуудлын хүрээнд цөөнгүй бүтээл бичигдсэн бөгөөд мэдээллийн нийгмийн мөн чанарын тухай асуудал судлаачдын маргаан мэтгэлцээний сэдэв болсоор удаж байна. Гэвч өнөөдөр хүртэл бүгдээрээ хүлээн зөвшөрсөн нэг мөр ойлголтод хараахан хүрч чадаагүй байна.

Судлаачдын орчин үеийн нийгэмд хандах хандлага, ойлголт тодорхой хэмжээгээр өөрчлөгдөж, асуудлыг арай өөр өнцгөөс авч үздэг болсон нь ажиглагддаг. Тэд орчин үеийн нийгмийн хамгийн гол онцлог шинж нь мэдээлэл гэдгийг онцлон тэмдэглэдэг болсон. Нэг хэсэг нь бид мэдээллийн эринд амьдарч байгаа учраас “мэдээллийн арга” давамгайлж байна, нөгөө хэсэг нь “цахим нийгэмд” амьдарч байгаа тул хөдөлгөгч хүч нь мэдээлэл

болсон “виртуаль эдийн засаг”-т ойртож байна, гурав дахь хэсэг нь бид аль хэдийд “даяаршлагдсан мэдээллийн эдийн засаг”-ийн нөхцөлд амьдарч байгаа талаар ярьж, бичиж байна. Зарим шинжээч улам цаашаа явах болж, АНУ, Их Британи, Япон, Герман зэрэг орныг мэдээллийн нийгмийн түвшинд дөхсөн гэж үздэг болжээ. Мэдээллийн нийгмийн талаарх үзэл баримтлал, бодлого тодорхойлог улс төрчид болон тэргүүлэх бизнесменүүдийн санаанд ч нийцэж байгааг ажиглаж болно. Тэр тусмаа Европын Холбоо 1970-аад оны эхэнд энэ үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрсөн Японы жишээгээр “даяаршлагдсан мэдээллийн нийгэм”-д хүрэхээр яарч байна.

Маргааны гол сэдэв нь нийгэмд гарч байгаа энэхүү өөрчлөлт нь чухам юу авчрах вэ гэдэг асуудлын хүрээнд голлон өрнөх болсон. Нэг хэсэг нь өөрийнхөө гишүүдэд үнэхээр халамжтай, мэргэжлийн үүднээс ханддаг нийгмийг цогцлон байгуулах, нөгөө хэсэг нь иргэдэд тавих хяналт хүчтэй болох, гурав дахь хэсэг нь өндөр боловсролтой давхарга бий болох, улс төрийн эдийн засагчид шинэ “цахим эдийн засаг”-т хурдан сэтгэдэх мэдлэг

эзэмшсэн үйлдвэрлэгчид давуу байр суурь эзлэх тухай ярих болсон бол соёл, кибер орон зай, виртуаль бодит байдлын төлөө санаа зовдог хүмүүс зохион бүтээх үйл ажиллагаа, сэтгэн бодох ажлын хувьд таагүй орон зай гэж үздэг байна.

Хэдийгээр үзэл бодлын ийм зөрчил байгаа ч бүх судлаач мэдээлэл бол ер бусын гайхамшигтай зүйл, орчин үеийн нийгэмд онцгой үүрэг гүйцэтгэдэг гэдгийг нэгэн дуугаар хүлээн зөвшөөрдөг. Мэдээллийн нийгмийн талаарх суурь бүтээлүүдэд тусгасан Дэниел Бэллийн гол амжилт нь мэдээллийг удирдлага болгодог үйлдвэрлэлийн дараах нийгмийн үзэл баримтлал, Мануэль Кастельсийн сүлжээний нийгэм дэх мэдээллийн капитализмын тухай нөлөөллийн онол, Герберт Шиллерийн хөгжингүй капитализмын мэдээллийн болон түүгээр удирдах хэрэгцээний талаарх үзэл бодол, Юрген Хабермасын олон нийтийн хүрээтэй хамт мэдээллийн үнэн бодитой шинж нь уналтад орох тухай дүгнэлт, Энтони Гидденсийн ажиглалт, хяналт тавих зорилгоор цуглуулдаг мэдээллийн үүрэгт онцгой анхаарал хандуулсан “рефлексив шинэчлэл”-ийн тухай эргэцүүлэл, Жан Бодийяр, Зигмунд Бауман нарын орчин үеийн нийгэм дэх тэмдэгтийн тэсрэлтэд гол анхаарлаа хандуулсан постмодернизм ба постмодернизмийн эриний тухай санаа бодол чухал байр эзэлдэг.

Энэ эрдэмтэд социологи, философи, түүх, эдийн засаг, газар зүй зэрэг олон шинжлэх ухааны зааг дээр ажилладаг, орчин үеийн нийгмийн шинжлэх ухааны маргаан мэтгэлцээний төвд байдаг нь ажиглагддаг. Үүнд гайхах хэрэггүй.

Нийгмийн ухааны салбарын сэтгэн бодогчид хамгийн гол шинж нь мэдээлэл болсон бидний амьдарч буй нийгмийг ойлгох, учрыг тайлах, тайлбарлахын тулд оршдог.

Мэдээллийн нийгмийн тухай ярихаас өмнө мэдээллийн тухай товч ойлголт өгөх нь зарчмын чухал ач холбогдолтой. Хамгийн түрүүнд энэ ойлголтыг утгын талаас нь авч үзэх шаардлагатай. Мэдээлэл өөрийн гэсэн агуулгатай, судлагдахуунтай. Энэ бол судлаачийн тодорхойлсноор “хэн нэгний, эсвэл ямар нэгэн зүйлийн тухай мэдээ, эсвэл үйлдэл хийхэд нөлөөлөх удирдлага”¹ юм. Хэрэв мэдээллийн нийгмийн онцлогийг ойлгохын тулд ийм үзэл баримтлалыг ашиглах юм бол үүний үр дүнд мэдээллийн дээрх шинжүүдийг нэг бүрчлэн тайлбарлах шаардлага гарах болно. Харин мэдээллийн нийгмийг судлаачдад мэдээллийн агуулгад бага анхаарч, тоон үзүүлэлтийг голлон хэрэглэх хандлага түгээмэл байдаг. Ингэхдээ 1949 онд боловсруулсан Клод Шэннон, Уоррен Уивер нарын мэдээлэл бол “бит” хэмжигдэхүүнээр хэмжиж болдог, тэмдэгтийн давтамжийн магадлалаар тодорхойлогддог тоон үзүүлэлт гэсэн санааг агуулсан мэдээллийн сонгодог онолд ханддаг.

Өдөр тутмын амьдралд бид мэдээллийг хүлээн авч, мэдээлэл солилцохдоо юуны өмнө түүний утга, үнэ цэнтэй эсэхэд гол анхаарлаа хандуулдаг. Өөрөөр хэлбэл үнэн бодитой, тодорхой, ашигтай, сонирхолтой, алдаа дутагдалтай эсэхийг үнэлэхийг оролддог. Гэхдээ мэдээллийн тэсрэлтийн олон хэмжүүрийн үндсийг бүрдүүлдэг мэдээллийн онолын хувьд

энэ хэмжигдэхүүнүүд учир дутагдалтай юм. Энэ онол мэдээллийн агуулгад огт холбоогүй тодорхойлолтыг өгөхийн хамт түүнийг энерги, матери зэрэг биет ертөнцийн хэсэгтэй адилтган үздэг. Энэ талаар мэдээллийн нийгмийн онолын нэрт судлаачдын нэг Т.Стониер: “Мэдээлэл оршдог. Оршихын тулд түүнийг заавал хүлээж авахыг шаардахгүй. Оршихын тулд түүнийг заавал ойлгохыг шаардахгүй. Өөрийгөө тайлбарлахын тулд оюуны хүчин чармайлт гаргахыг бас шаардахгүй. Оршихын тулд түүнд утга санаа шаардахгүй. Мэдээлэл оршдог”² гэж бичсэн байдаг.

Хэрэв үнэхээр тийм бол нэг нь гүнзгий агуулгатай, нөгөө нь ямар ч утга учиргүй хоёр мэдээ яг адилхан гэсэн үг. Тэгвэл өөр нэг судлаач Розак: “Утга агуулгаас нь үл шалтгаалан эх сурвалжаас хүлээн авагчдад харилцааны сувгуудаар дамжуулж буй бүх зүйлийг мэдээлэл гэдэг үгээр илэрхийлэх болсон”³ гэж тэмдэглэснийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй юм. Энэ бол мэдээллийг агуулга, чанараар нь биш тоо хэмжээгээр нь төсөөлөхөд хүргэх нь тодорхой.

Мэдээллийн ийм тодорхойлолт мэдээллийн нийгмийн зөвхөн технологийн болон орон зайн үзэл баримтлалд (дамжуулж, боловсруулж, хадгалсан мэдээллийн тоо хэмжээ бүтээмжийн хэмжүүр болох тохиолдолд) байдаг зүйл биш бөгөөд эдийн засгийн үзэл баримтлалд ч мэдээллийн агуулгыг тийм маягаар гүйвуулсан тохиолдол цөөнгүй тааралддаг. Энд хэдийгээр “бит” хэмжигдэхүүнийг ашиглахгүй ч агуулгыг ерөнхий үзүүлэлтээр үгүйсгэдэг нь энгийн үзэгдэл.

Мэдээллийн нийгмийн онолчид мэдээллийн агуулгыг үгүйсгэж, тоо хэмжээнд илүү их ач холбогдол өгч, үйлдвэрлэж буй мэдээллийн тоо, эдийн засгийн жин, эсвэл зүгээр л биднийг хүрээлж байгаа тэмдэгтүүдийн өсөлтийн ачаар нийгэм агуулгын хувьд томоохон өөрчлөлтөд орох болно гэсэн дүгнэлт хийдэг. Энэ бол мэдээллийн нийгмийн бус үнэлэлт буюу мэдээлэл зүгээр л оршиж байдаг, нийгмийн ямар ч үр дагаваргүй гэдэгтэй адилхан дүгнэлт юм. Мэдээллийн түгээлтийг тоон үзүүлэлтээр хэмжих нь ямар ч ач холбогдолгүй зүйл биш боловч хангалттай үндэслэл биш юм. Мэдээллийн нийгмийн тухай хангалттай мэдлэг олж авах, нийгмийн бусад системтэй юугаар төстэй, юугаар ялгаатай вэ гэдгийг мэдэхийн тулд мэдээллийн агуулга ба чанарыг заавал судлах шаардлагатай. Тийм учраас мэдээллийн нийгмийг судалдаг онолчид мэдээлэл нэмэгдсэн гэдгийг хүлээн зөвшөөрдөг ч түүнийг агуулгаас нь салгаж үзэхээс татгалзахын (тэд үргэлж “Ямар мэдээлэл вэ?” гэж асуудаг) зэрэгцээ зарим нь мэдээллийн үйлдвэрлэл мэдээллийн нийгэм үүсэхэд нөлөөлсөн гол хүчин зүйл биш гэж үздэг. Тэд мэдээллийг агуулгын хувьд ч, тооны хувьд ч онцгойлон судлах шаардлагагүй, харин хамгийн гол тооны өөрчлөлт мэдээллийг ашиглах арга барилд гарсан гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Энэ чиглэлийг баримталдаг судлаачдын хувьд мэдээллийн нийгэм гэдэг нь түүнд онолын мэдлэг гол үүрэг гүйцэтгэдэг нийгэм мөн гэж үздэг байна. Энэ бол үнэхээр зуун хувь дэмжихээс өөр аргагүй дүгнэлт мөн.

Одоо мэдээллийн нийгмийн шалгуурын тухай тогтож ярихыг оролдъё. Судлаачид мэдээллийн нийгмийн талаар янз бүрийн тодорхойлолт өгч, түүний нэлээд хэдэн шалгуурыг санал болгосон байдаг. Ихэнх судлаачийн санал нийлж байгаа гол шалгуур бол технологийн, эдийн засгийн, хөдөлмөрийн салбартай холбоотой, орон зайн, соёлын гэсэн таван шалгуур юм. Судлаачдын өгсөн, тодорхойлолт, шалгууруудын гол эх суурийг нэг л санаа бүрдүүлж байгааг ажиглаж болно. Энэ бол мэдээллийн хүрээн дэх тооны өөрчлөлт нийгмийн байгууллын чанарын шинэ хэв маяг болох мэдээллийн нийгэм үүсэхэд нөлөөлсөн, орчин үед мэдээлэл нэмэгдсэн, тиймээс бидний амьдарч буй нийгэм мэдээллийн мөн гэсэн санаа юм. Бас өөр тодорхойлолтууд ч байна. Тухайлбал, орчин үед мэдээлэл эрс нэмэгдсэн, энэ мэдээллийн шинж чанар бидний аж төрөх ёсыг өөрчилсөн гэсэн өмнөхөөс өөр тодорхойлолт юм. Энэ бол өнөөдөр бидний зан байдлын үндсийг онолын мэдлэг (мэдээлэл) бүрдүүлж байна гэдгийг илэрхийлж байгаа бөгөөд мэдээллийн тоог биш, чанарыг харгалзан үзсэн цорын ганц тодорхойлолт гэж хэлж болно. Хэдийгээр мэдээллийн нийгмийг судлаачдын ихэнх нь чанараасаа илүү тоо хэмжээг эрхэмлэдэг ч дээрх

тодорхойлолт хамгийн үнэмшилтэй үндэслэл байж болох юм.

Технологийн шалгуур. Технологийн үзэл баримтлалын үндсийг 1970-аад оны эцэст эхэлсэн технологийн инноваци бүрдүүлдэг. Шинэ технологи

шинэ цаг үе эхэлсний буюу мэдээллийн нийгэм эхэлж буйн шинж гэж үздэг. Үүний үндэслэл нь кабелийн ба сансрын телевиз, компьютерийн сүлжээ, персональ компьютер, албан тасалгааны шинэ технологи, мэдээллийн онлайн үйлчилгээ, эх бичвэрийг хянан найруулах систем, CD-ROM юм.

«

Судлаачид мэдээллийн нийгмийн талаар янз бүрийн тодорхойлолт өгч, түүний нэлээд хэдэн шалгуурыг санал болгосон байдаг. Ихэнх судлаачийн санал нийлж байгаа гол шалгуур бол технологийн, эдийн засгийн, хөдөлмөрийн салбартай холбоотой, орон зайн, соёлын гэсэн таван шалгуур юм

»

Гол санаа нь технологийн инновацийн тийм дэвшлийн нийгэмд үзүүлэх нөлөө нь асар хүчтэй учраас нийгмийг өөрчлөн байгуулахад хүргэнэ гэдэгт оршиж байв.

1970-аад оны эцэс, 1980-аад оны эхэнд судлаачид “агуу их микро”-ны тухай үзэл баримтлалыг хүчтэй дэмжиж, бидний аж төрөх ёсыг үндсээр нь өөрчлөх болно гэдэгт итгэж байлаа. Тэдний дотор хамгийн их сэтгэл нь хөдөлсөн хүний нэг бол нэрт футурологич Элвин Тоффлер бөгөөд тэрээр өөрийнхөө гол санааг “дэлхийг технологийн гурван давалгаа бүрдүүлж байгаа бөгөөд тэд маш хүчтэй далайн хөөрөлттэй адил учраас зогсоох боломжгүй. Эхнийх хөдөө аж ахуйнх, хоёр дахь нь аж үйлдвэрийнх байсан. Одоо амьдралын шинэ хэв маягийн

дохио болох гурав дахь давалгаа буюу мэдээллийн хувьсгал ойртож байна” гэж илэрхийлсэн байдаг. Сүүлд энэ санааг компьютерийн технологийн теле харилцааг өөрчлөх, энэ хоёр технолгийг нэгтгэх боломжоор баяжуулж байсан бол орчин үед харилцааны тоон технологи өргөн дэлгэрсэн нь шинэ нийгэм төлөвшиж эхэлсний илрэл гэж үздэг болсон.

Бодит цаг хугацаанд эдийн засгийн амжилт олох, ардчилалд суралцахад нөлөөлөх боломж олгодог Интернет эерэг ч, сөрөг ч тайлбар, мэтгэлцээний сэдэв болон хувирсан. Хэрэв үнэхээр эрүүл ухаанаар тунгаан бодох юм бол банк, корпораци, засгийн газар, олон нийтийн байгууллагууд зөвхөн тухайн улсын хэмжээнд төдийгүй, олон улсын хэмжээнд даяар түвшинд мэдээлэл солилцох болсон нь орон зай, цаг хугацааг үл харгалзан компьютерийн эгшин зуурын харилцааг хангаж чадахуйц технологийн дэд бүтцийг төлөвшүүлж буйн илрэл юм. Тухайлбал, мэдээллийн нийгмийн өсөлтийг тооцоолох оролдлого бүр 1960-аад оноос эхэлж, 1975 оноос өндөр түвшний техник хэрэгслийн тусламжтайгаар утасны ярианы хугацаа, телекоммуникацийн тоног төхөөрөмжийн тархалтыг тусгайлан судлах болсон. Их Британийн судлаачид мэдээллийн болон харилцааны технологи шинэ эриний эхлэл тавигдсаны илрэл мөн, гэхдээ эхний шатанд багагүй бэрхшээл тугардаг боловч дараагийн шатанд эдийн засгийн хувьд маш ашигтай байх болно. Энэхүү шинэ “техноэдийн засгийн парадигм” “мэдээллийн зуун”-

ы илэрхийлэл бөгөөд XXI зууны эхээр хөгжлийн нэлээд боловсронгуй түвшинд хүрэх болно гэсэн дүгнэлтэд хүрчээ. Эрчим хүч, уурын тогоо, дотоод шаталтын хөдөлгүүр, усан онгоц зэрэг техникийн зохион бүтээлт аж үйлдвэрийн нийгмийн үндсэн шинж болж байсан бол орчин үеийн нийгэмд мэдээлэл-харилцааны шинэ технологи тийм үүрэг гүйцэтгэж байна. Энэ талаар судлаач Жон Нэсбитийн “Аж үйлдвэрийн хувьсгалын хувьд механикжуулалт ямар үүрэгтэй байсан, компьютерийн технологи мэдээллийн зууны хувьд яг тийм үүрэгтэй байна”⁴ гэсэн чухал дүгнэлт хийсэн байдаг.

Гэхдээ мэдээллийн нийгмийн технологийн шалгуурт шүүмжлэлтэй ханддаг судлаачид бас бий. Шүүмжлэгчид түүхэн эрин болгонд эхлээд технологийг бүтээдэг, дараа нь хүмүүсийг шинэ нөхцөлд дасан зохицохыг шаардах замаар нийгэмд нөлөө үзүүлнэ гэсэн санааг эсэргүүцдэг. Тийм дүгнэлтэд гол ач холбогдлыг технологид өгч, түүнийг нийгмийн хөгжлийн хөдөлгүүр болгон тодорхойлсон нь нийгмийн өөрчлөлтийн үйл явцыг дэндүү хялбарчилж буй хэрэг гэж үздэг. Өөрөөр хэлбэл технологийн инновациас нийгэм, эдийн засаг, улс төрийн хэмжүүрийг салгаж болохгүй гэсэн дүгнэлтэд хүрсэн байдаг. Гэхдээ энд нэг зүйлийг онцлон тодруулахад технологийг нийгмийн салбараас тусгайлан авч үзэж болохгүй. Эсрэгээр технологи нийгмийн салшгүй хэсэг болдог. Тухайлбал, аливаа судалгаа, шинжлэх ухааны боловсруулалт хийх талаар шийдвэр гаргахдаа юуны өмнө түүний нийгмийн ач холбогдлыг харгалзан үзэж, энэхүү

үнэлэмжийн үндсэн дээр технологи хөгждөг учиртай юм.

Дүгнэж хэлэхэд мэдээлэл-харилцааны технологи дангаараа мэдээллийн нийгмийн шалгуур биш, зөвхөн түүний бүрэлдэхүүн хэсэг болдог, харин нийгмийн бусад хэмжүүртэй салшгүй харилцаа холбоонд оршсон нөхцөлд гол үүрэг гүйцэтгэх бүрэн боломжтой юм.

Эдийн засгийн шалгуур. Энэ бол мэдээллийн үйл ажиллагааны эдийн засгийн үнэ цэнийн өсөлтийг тооцох хандлага юм. Хэрэв хүн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх мэдээллийн бизнесийн хэмжээг өсгөж чадсан тохиолдолд эдийн засаг мэдээллийн болж чадна гэсэн дүгнэлтэд хүрч болно. Хэрэв эдийн засгийн хүрээнд мэдээлэл хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарт давамгайл байр суурь эзэлж чадсан бол мэдээллийн нийгмийн тухай ярих боломжтой. Энэ бол мэдээллийн нийгмийн эдийн засгийн шалгуурыг гол болгодог судлаачдын үзэл баримтлал юм.

Эдийн засгийн шалгуурын асуудлыг анх хөндөж тавьсан судлаач бол Принстоны их сургуулийн профессор Фриц Махлуп бөгөөд тэрээр боловсрол, ОНМХ, эрх зүй, хэвлэх үйлдвэр, компьютерийн үйлдвэрлэлийг мэдээллийн салбарт хамруулж, тэдний байнга өөрчлөгдөж буй эдийн засгийн үнэлэмжийг тогтоохыг оролджээ. Хожим энэ асуудлыг шийдвэрлэхэд Марк Порат томоохон хувь нэмэр оруулж, эдийн засгийн мэдээллийн нэг дэх ба хоёр дахь секторын хоорондох ялгааг тодорхойлсон гавьяатай. Эхний сектор эдийн засгийн хувьд нарийн үнэлэх боломжтой, зэх зээлийн

үнэлгээтэй бол хоёр дахь сектор (оюуны хөдөлмөр давамгайлсан) компани, төрийн байгууллагуудын дотроо явагддаг мэдээллийн үйл ажиллагаа тул үнэлэхэд хүндрэлтэй гэж үзсэн байдаг. Дараа нь энэ хоёр секторыг нэгтгэх замаар тэдний эдийн засгийн элементүүдийг ялган авч, үндэсний эдийн засгийн статистикт дүн шинжилгээ хийсний үндсэн дээр АНУ-ын дотоодын нийт бүтээгдэхүүний тэн хагас нь энэхүү нэгдсэн хоёр сектортой холбоотой, өөрөөр хэлбэл “АНУ-ын эдийн засаг мэдээлэлд үндэслэгдсэн” гэсэн дүгнэлтэд хүрчээ. Тийм учраас судлаачдын хэлснээр “АНУ бол мэдээллийн нийгэм мөн, учир нь энд мэдээллийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мэдээллийн үйлчилгээний үйл ажиллагаа, мөн нийгмийн ба хувийн (хоёр дахь мэдээллийн сектор) бичиг хэрэг эрхлэх ажил гол байр эзэлдэг байна”⁵.

Мэдээллийн эдийн засгийн ач холбогдлын тоон үзүүлэлтийн судалгаа бол чухал үндэслэл мөн. Гэхдээ бусад судлаачид тоон үзүүлэлтийн тайлбарт субъектив үнэлэлт, санаа бодол нуугдаж байдаг тул категориудыг яаж байрлуулах, мэдээллийн секторт чухам юуг оруулж, юуг авч хаях вэ гэдгийг нарийн тодруулах шаардлагатай гэж үздэг.

Энд судлаачдын хөнддөг өөр нэг асуудал бол дээр дурдсан тоон мэдээллүүд эдийн засгийн үйл ажиллагааны янз бүрийн төрлийг ижил түвшинд авч үзэхэд хүргэдэгт оршино. Тухайлбал, реклам болон телевизийн эзлэх хувь эрс нэмэгдэж байгаа нь эдийн засгийн үүднээс авч үзвэл мэдээллийн нийгмийн үзүүлт мөн.

Гэхдээ энд мэдээллийн үйл ажиллагааны чанарын ялгааг тогтоох, мөн эдийн засгийн мэдээллийн секторын хэмжээг тодорхойлох боломжгүй юм. Мэдээж Махлуп, Порат нар мэдээллийн нийгмийн тооны болон чанарын онцлог шинжийг ялгаж үзэх зорилго тавиагүй байж болно. Тухайлбал, олон сая хувиар хэвлэгддэг “Сан” сонины эдийн засгийн үнэ цэнийг 400 мянган хувиар хэвлэгддэг “Файненшл таймс” сонинтой харьцуулахад хэдийгээр илүү их мэдээлэл агуулдаг ч эргэлзээтэй гэдэг нь тодорхой.

Үүнээс үзэхэд мэдээллийн нийгмийн эдийн засгийн шалгуур нь зөвхөн тоон үзүүлэлтээр биш, чанарын үзүүлэлтээр давхар тодорхойлогдох учиртай юм.

Хүн амын ажил эрхлэлтийн асуудалтай холбоотой шалгуур. Энэ хандлага “үйлдвэрлэлийн дараах нийгэм”-ийн нэрт онолч Д.Беллийн бүтээлүүдтэй шууд холбоотой бөгөөд социологичдод илүү ихээр таалагддаг. Үзэл баримтлалын гол утга санаа нь хөдөлмөр эрхлэгчдийн ихэнх нь мэдээллийн салбарт ажиллах тохиолдолд мэдээллийн нийгэмд орох болно гэдэгт оршино. Өөрөөр хэлбэл үйлдвэрийн салбарт ажиллагсдын тоо буурч биеийн хөдөлмөрийг “цагаан захтан”-ы хөдөлмөрөөр солино гэсэн үг юм. Өнөөдөр Баруун Европ, Хойд Америк, Японд ажиллах хүчний 70 гаруй хувь нь үйлчилгээний салбарт ажиллаж, “цагаан захтан”-ы ажил давамгайлж болсон. “Хөдөлмөр эрхлэгчдийн хүрээнд мэдээллийн салбарт ажиллагсдын бүлэг давамгайлж байгаа нь”⁶ бид мэдээллийн нийгэмд амьдарч байгаагийн баталгаа юм. Энэ бол

мэдээлэл, харилцааны технологийг гол болгодог судлаачдын үзэл баримтлалаас хөдөлмөр эрхлэлтийн хүрээн дэх өөрчлөлтийг үндсэн шалгуур болгож байгаагаараа зарчмын ялгаатай юм. Энд мэдээллийн үйлдвэрлэл ажил эрхлэлтийн хүрээнд шилжиж, хүмүүсийн сургалт, туршлагаар дамжин практикт хэрэгждэг.

Энэ шалгуурыг дэмжигч судлаачдын ихэнх нь орчин үеийн эдийн засгийн хөдөлгөгч хүч нь авьяас чадвар нь мэдээллийг ашиглахад оршдог хүмүүс гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Хэдийгээр орчин үед судлаачид “бэлгэдлийн аналитикууд”, “шинжээчид”, “мэдээллийн хөдөлмөр” зэрэг янз бүрийн нэр томъёо хэрэглэж байгаа ч тэдний ерөнхий утга санаа нь адилхан буюу өнөөдөр эдийн засгийн гол хөдөлгүүр нь мэдээллийг бүтээгчид ба ашиглагчид мөн гэдгийг нэгэн дуугаар хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ мэдээллийн ажлын тоон үзүүлэлт, мэдээллийн үйл ажиллагааны тодорхой хэв маяг нь нийгэмд тийм ч чухал нөлөөтэй биш гэдгийг бүрэн илрүүлж чадахгүй. Өөрөөр хэлбэл зөвхөн тоон үзүүлэлт биш мэдээллийн ажлын чанар, ач холбогдол, үр нөлөөг харгалзан үзэх нь чухал гэсэн санааг баримтлагчдыг дэмжих нь зөв юм. Тиймээс мэдээллийн ажилтнуудын янз бүрийн бүлгийг чанарын хувьд ялгаж үзэх, үнэлэлт дүгнэлт өгөх нь зүйд нийцнэ.

Орон зайн шалгуур. Мэдээллийн нийгмийн зарим үзэл баримтлал нь хэдийгээр эдийн засаг, социологид тулгуурладаг боловч газар зүйн зарчимд үндэслэгддэг нь ажиглагддаг. Энд гол анхаарлаа янз бүрийн газрыг

хооронд нь холбож өгдөг мэдээллийн сүлжээнд хандуулж, сүлжээ цаг хугацаа, орон зайн зохион байгуулалтад хүчтэй нөлөө үзүүлдэг гэж үздэг байна. Сүүлийн жилүүдэд мэдээллийн сүлжээ нийгмийн байгууллагуудад чухал үүрэг гүйцэтгэх болсноос шалтгаалан энэ үзэл баримтлал өргөн дэлгэрсэн. Мэдээллийн сүлжээ зөвхөн байгууллагын дотроо төдийгүй албан өрөөнөөс гадна хот, дүүрэг, тив, дэлхий дахины янз бүрийн цэгийг хооронд нь холбож чаддаг учраас онцгой ач холбогдол өгдөг боллоо.

Бид өдрөөс өдөрт сүлжээний ажилд хүссэн ч эс хүссэн ч татагдан орж, тийм ажилтай янз бүрийн түвшинд, газар сайгүй тааралдах болсны зэрэгцээ Интернетийн тусламжтайгаар дэлхийн өнцөг бүрээс мэдээлэл хүлээн авч, дамжуулж, солилцох болоод байна. Бид өөрсдөө кибер орон зайтай харьцах туршлагагүй байсан ч мэдээллийн цагираган шугам (магистраль) олон улсын банкууд, засгийн газар хоорондын байгууллагууд, нэгдсэн харилцааны түвшинд улам бүр идэвхтэй нэвтрэх болсон.

Цахим “супермагистраль” бий болсноор мэдээллийн урсгалд дахин анхаарал хандуулж, цаг хугацаа-орон зайн хоорондох харилцааг эргэж харах шаардлагатай гэсэн санаа өргөн дэлгэрч эхэлсэн юм. Сүлжээний нийгэмд орон зай, цаг хугацаатай холбоотой бэрхшээл аажим аажмаар арилж, өнөөдөр байгууллагуудаас гадна хувь хүн хүртэл өөрийнхөө ажлыг даяар хүрээнд үр ашигтай явуулж чаддаг болсон. Эрдэмтэд шаардла-

гатай мэдээллээ Интернетээр дамжуулан авах болсноор дэлхийн шилдэг номын санд суух гээд гадаадад явах шаардлагагүй, менежерүүд өөр хот, оронд байгаа үйлдвэрийн салбарын үйл ажиллагаатай Интернетээр танилцаж, хянах бүрэн боломжтой болсон. Тиймээс судлаачид үүнийг нийгмийн тогтолцооны томоохон өөрчлөлтийн эхлэл бөгөөд цаашид хувьсгалт өөрчлөлтөд хүргэнэ гэж үздэг болжээ.

Мэдээллийн сүлжээ орчин үеийн нийгмийн онцгой шинж гэдэгтэй хэн ч маргахгүй. Гэхдээ бид мэдээллийн нийгмийн технологийн тодорхойлолтыг ашиглаж байна уу, өөрөөр хэлбэл сүлжээг технологийн систем гэж нэрлэж болох уу, мэдээллийн ямар хэмжээ, эсвэл түүнийг дамжуулах хурд мэдээллийн нийгэм эхэлснийг тодорхойлох вэ гэсэн асуулт зүй ёсоор тавигдах болно. Мэдээллийн сүлжээ нэлээд эртнээс үүссэн, хамгийн наад зах нь эхлээд шуудан холбоо, дараа нь цахилгаан холбоо, телефон бий болсон цагаас үүссэн нь тодорхой. Эдийн засаг, улс төр, нийгмийн үйл ажиллагааны тодорхой хэсгийг энэхүү мэдээллийн сүлжээгүйгээр төсөөлөх боломжгүй. Энэхүү харилцаа холбооны урт хугацаанд үргэлжилснийг харгалзан үзвэл судлаачид мэдээллийн нийгмийн тухай яагаад дөнгөж өнөөдөр ярьж эхэлсэн бэ? Үүнээс мэдээллийн сүлжээ мэдээллийн нийгмийн гол шалгуур биш гэсэн дүгнэлт хийж болно.

Соёлын шалгуур. Энэ бол өмнөх шалгууруутай харьцуулахад ойлгоход амар хялбар боловч хамгийн хэмжих боломжгүй шалгуур юм. Нийгмийн амьдралд мэдээлэлтэй харьцах явдал урьд өмнө байгаагүй хэмжээнд өссөн

гэдгийг хүн болгон мэднэ. Телевизийг олон сувгаар 24 цагийн турш үздэг боллоо. Видеотехнологи, кабелийн, сансрын сувгийг ашиглаж, одоо тоон технологид шилжсэн. Персональ болон халаасны компьютер, ухаалаг гар утас олон нийтийг байлдан дагуулж, хаана ч радио сонсож, кино үздэг боллоо. Одоо рекламн самбаргүй гудамж, ном, сонин хэвлэл, дуу, дүрс бичлэгийн диск зарахгүй дэлгүүр, үйлчилгээний цэг ч үгүй болсон. Энэ бүхэн нь бид медиа ачааллын орчинд амьдарч, мэдээллийн нөлөө бидний оюун санаанд улам хүчтэй, гүнзгий нэвтэрч буйн илрэл юм. Бүр товчоор хэлбэл нийгмийн харилцааны мэдээллийн агуулга улам бүр ач холбогдолтой болж байна. Мэдээллийн нөлөөгөөр хүмүүсийн гадаад дүр төрх, өмсөх хувцас, хэрэглэх эд бараа, аж төрөх ёс нь хүртэл өөрчлөгдөж байгааг олон жишээгээр тайлбарлаж болно.

Орчин үеийн соёл өмнөх үетэй харьцуулахад өндөр түвшинд мэдээлэлжигдсэн. Амьдрал улам бүр бэлгэдлийн шинжтэй болж, өөрсдийн болон бусдын тухай мэдээллийг солилцох, хүлээж авах үйл явц дунд, эсвэл мэдээлэл солилцох, татгалзах оролдлогын дунд өрнөж байна. Энэ бүхэн нь зарим судлаачийн хувьд мэдээллийн нийгэмд орсны жишээ болж, тэд үүнийг тоон үзүүлэлтийн тусламжтайгаар тайлбарлахыг оролдох болсон. Энэ талаар нэрт социологич Жан Бодрийяр: “Мэдээлэл нэмэгдэж, утга агуулга нь багассаар байна”⁷ гэж дүгнэсэн нь санамсаргүй хэрэг биш юм.

Э нэхүү технологийн, эдийн засгийн, ажил эрхлэлтийн, орон зайн, соёлын зэрэг

шалгуурыг нэг бүрчлэн үзсэний дараа аль нэг нь бүрэн бус, аль нэг нь тодорхой бус, эсвэл зарим нь аль алиныг давхар агуулж буйг харж болно. Харин хамгийн гол асуудал тоон болон чанарын хэмжүүр хоорондоо ихээхэн зөрчилтэй байгаад оршино. Гэхдээ дээрх шалгуурууд мэдээллийн нийгмийн талаар бүрэн биш юмаа гэхээд тодорхой хэмжээгээр төсөөлөл өгөх нь тодорхой.

Хэрэв дээрх шалгуурын үүднээс авч үзвэл өнөөгийн Монгол Улсад мэдээллийн нийгмийн ямар нэгэн шинж байгаа эсэхийг тодруулах нь тийм ч хүнд ажил биш юм. Технологийн шалгуурын хувьд манай оронд үйлдвэрлэлийн талаас нь ярих юм хомс ч шинэ технологи нийгмийн бүх салбарт идэвхтэй нэвтэрч байгааг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Гэхдээ мэдээллийн нийгмийн шинжийг илэрхийлэх тэр түвшинд хараахан хүрээгүй байна. Харин эдийн засгийн шалгуурын хувьд мэдээллийн нийгэмтэй холбон ярихад арай эрт бөгөөд мэдээллийн үйл ажиллагааны эдийн засгийн үнэ цэн өсөх, нийгэмд гол үүрэг гүйцэтгэх болоогүй байна. Өөрөөр хэлбэл мэдлэг, мэдээллийг мөнгө болгон хувиргах үйл явц дөнгөж эхлэл төдий юм. Мэдээллийн хүрээнд ажиллагсдын тоо жилээс жилд нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаа ч дэлхийн өдөр хөгжилтэй орнуудтай харьцуулахад нийт ажиллагсдын өчүүхэн хувийг эзэлдэг. Энэ асуудал өөрөө технологийн дэвшлээс шууд шалтгаалах учраас техник, технологийн асуудлыг шийдвэрлэхгүйгээр мэдээллийн нийгмийн тухай ярих боломжгүй юм. Харин орон зайн шалгуур буюу мэдээллийн

сүлжээ, соёлын шалгуурын хувьд нааштай алхам ажиглагдаж байна. Нийгмийн ямар ч харилцаанд мэдээллийн сүлжээ чухал байр эзлэх болсон. Ганц жишээ дурдахад өнөөдөр манай хүлээн авагчид кабелийн телевизийн 200 орчим сувгаар 20 гаруй хэл дээр мэдээлэл хүлээн авч, өдөр тутмын 16 сонин гарч, Улаанбаатарт 32, Монгол Улсын нутаг дэвсгэрт 162 телевиз үйл ажиллагаа явуулж байна. Улсын хэмжээнд 84 радио үйл ажиллагаа явуулж байгаагийн 77 нь хэт богино долгионы радио станцууд (FM) юм. Өргөн нэвтрүүлгийн 16 телевиз байгаагийн дотор 2005 оноос MN 25-р суваг, TV-5, TV-9 зэрэг 10 гаруй телевиз орон даяар нэвтрүүлгээ цацаж эхэлсэн бөгөөд үндэсний хэмжээнд нэвтрүүлгээ цацдаг телевизүүд өдөрт дунджаар 16-18 цагийн хөтөлбөртэй байна. МҮОНТ-ээс гадна TV-5, TV-9 зэрэг телевизүүд 24 цагаар ажиллаж байна. Гадаадын хөрөнгө оруулалттай ХМХ-ийн тоо ч нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. 135 сонин, 120 сэтгүүл гарч байгаа нь хүн амын тоотой харьцуулахад өндөр үзүүлэлт юм. Интернетийн хэрэглээ 2002 онтой харьцуулахад 400 дахин өсч, 300 гаруй суманд Интернет хэрэглэж байна.

Хэрэв Интернет хэрэглэгчдийн тоо 2007 онд 17329, 2010 онд 199849 байсан бол 2015 оны 3 дугаар сарын байдлаар 2.1 саяд⁸ хүрчээ. Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо 2016 онд давхардсан тоогоор 5 сая орчим болж, 100 хүнд 165 үүрэн телефон ногдож буй нь дэлхийд зөвхөн Хонхонг (240), Арабын нэгдсэн Эмират (204), Монтенегро (178), Саудын Арабын (169) дараа орох үзүүлэлт юм⁹.

Мөн жилд дунджаар 4.5 тэрбум минут утсаар ярьдаг гэсэн тооцоо гарчээ. Түүнчлэн *Facebook*, *Twitter* зэрэг нийгмийн сүлжээг хэрэглэгчдийн тоо өдрөөс өдөрт нэмэгдэж, зөвхөн *Facebook*-ийг хэрэглэгчдийн тоо 400 мянгад хүрч, нийгмийн мэдээллийн сүлжээ сайтуудыг манай орны нийт хүн амын гуравны нэг буюу 1.1 сая хүн хэрэглэж байна гэсэн тоон үзүүлэлт бий. Нийгмийн сүлжээнд төрийн тэргүүнээс эхлээд ерөнхий боловсролын сургуулийн сурагч хүртэл бүх насны хүмүүс хамрагдах болсон нь шинэ үзэгдэл юм. Манай орон өнөөдөр 1000 хүнд ноогдох ХМХ-ийн тоогоор болон нийт иргэдийн телефон хэрэглээгээр дэлхийн дундаж хөгжилтэй орнуудын үзүүлэлтээс өндөр байна¹⁰. Энэ бол мэдээллийн даяаршил ямар түвшинд байгааг харуулах энгийн жишээ мөн. Өөрөөр хэлбэл 1960-аад оны дунд үед Канадын нэрт философич Маршал Маклюэний зөгнөн хэлсэн “даяар тосгон”-ы тухай үзэл баримтлал өнөөдөр бодит үзэгдэл болж буйн илрэл юм.

Гэхдээ энэ нь орон зайн талаас нь авч үзвэл жигд биш хүн амын гуравны нэг нь Интернетийн сүлжээнд зохих хэмжээгээр холбогдож чадаагүй байгаагийн хамт Интернетийн үйлчилгээ үнэтэй, дэд бүтэц хөгжөөгүй, дунд болон ядуучуудын давхарга давамгайлдаг, ажилгүйдэл ихтэй зэрэг үүнд олон хүчин зүйл нөлөөлж байна. Нөгөө талаар мэдээллийн технологийг хурдан шуурхай нэвтрүүлэх материал-техникийн бааз дутмаг, энэ салбарын мэдлэг боловсролтой, дадлага туршлагатай боловсон хүчин ч хангалттай биш байна. Өнөөдөр манай оронд мэдээл-

лийн технологи, мэдээллийн нийгэм байгуулахаас түрүүнд шийдвэрлэх эдийн засгийн хямралаас богино хугацаанд хохирол багатай гарах, иргэдийг ажил төрөлтэй, орон байртай болгох, эрүүл мэнд, боловсролын салбарт тулгамдсан асуудлыг яаралтай шийдвэрлэх, ХАА болон уул уурхайн салбарыг хөгжүүлэх зэрэг тулгамдсан асуудал их байна. Энэ бүхнийг нааштай шийдвэрлээгүй нөхцөлд мэдээллийн нийгэм бидний хувьд ойрын арав, хорин жилд мөрөөдөл төдий зүйл гэдэг нь тодорхой юм.

Ишлэл

¹ *Уэбстер Ф.* 2004. Теории информационного общества. М., с.34.

² *Stioner, Tom.* 1990. Information and the Internal Structure of the Universe: An Exploration into Information Physics. Springer-Verlag, p.21.

³ *Roszak, Theodore.* 1986. The Cult of Information: The Folklore of Computers and the True Art of Thinking. Cambridge: Lutterworth, p.13.

⁴ *Naisbitt, John.* 1984. Megatrends: Ten New Directions Transforming our Lives. Futura. p. 28.

⁵ *Porat, Mark Uri.* 1978. Communication Policy in an Information Society, in Robinson, G.O. 90 ed., p.32.

⁶ *Bell, Daniel.* 1979. The Social Framework of the Information Society, in Dertouzous, Michail L. and Moses, Joel (eds), p.183.

⁷ *Baudrillard, Jean.* 1983. In the Shadow os the Silent Majorities, or, The End of the Social and Other Essays. Translated by Paul Foss, John Johnson and Paul Patton. New-York: Semiotext(e), p. 95.

⁸ Монголд Интернет нэвтэрсний 20 жилийн ой тохиож байна // "Өнөөдөр". 2016.01.05, №011.

⁹ *Жаргалсайхан Д.* Тоон технологийн хөгжлийн товгүй унац // "Өнөөдөр". 2016.03.02.

¹⁰ *Зулькафиль М.* 2016. Орчин үеийн медиа: шинэчлэл, чиг хандлага. УБ., х. 193-194.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Baudrillard, Jean.* 1983. In the Shadow os the Silent Majorities, or, The End of the Social and Other Essays. Translated by Paul Foss, John Johnson and Paul Patton. New-York: Semiotext(e).

2. *Bell, Daniel.* 1979. The Social Framework of the Information Society, in Dertouzous, Michail L. and Moses, Joel (eds).

3. *Naisbitt, John.* 1984. Megatrends: Ten New Directions Transforming our Lives. Futura.

4. *Porat, Mark Uri.* 1978. Communication Policy in an Information Society, in Robinson, G.O. 90 ed.

5. *Roszak, Theodore.* 1986. The Cult of Information: The Folklore of Computers and the True Art of Thinking. Cambridge: Lutterworth.

6. *Stioner, Tom.* 1990. Information and the Internal Structure of the Universe: An Exploration into Information Physics. Springer-Verlag.

7. *Жаргалсайхан Д.* Тоон технологийн хөгжлийн товгүй унац // "Өнөөдөр". 2016.03.02.

8. *Зулькафиль М.* 2016. Орчин үеийн Медиа: шинэчлэл, чиг хандлага. УБ.

9. Монголд Интернет нэвтэрсний 20 жилийн ой тохиож байна // "Өнөөдөр". 2016.01.05, №011.

10. *Уэбстер Ф.* 2004. Теории информационного общества. М.

Резюме

В данной статье автор, опираясь на концепции и выводы известных учёных Запада об информационном обществе, выделяет такие основные критерии информационного общества, как технологический, экономический, связанный со сферой занятости, пространственный и культурный. На основе этих критериев и конкретных примеров из жизни людей

автор старается выделить некоторые признаки информационного общества, присущие общественной жизни современной Монголии. Также автор делает вывод

о том, что для нового наступающего общества, кроме информатизации всех его отраслей, ведущую роль играет теоретическое знание.